

Мэндчилгээ

Эрхэм уншигч таны энэ өдрийн амар амгаланг эрэн мэндчилье.

Монгол Улсын Их Сургууль эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээ өргөжүүлэх, салбар дундын судалгааны санаачлагыг дэмжин дэлгэрүүлэх, судалгааны үндэслэлтэй мэдээлэл, зөвлөгөөгөөр нийгэм, олон нийтэд үйлчлэх зорилгоо хэрэгжүүлэх ажлын хүрээнд дэргэдээ Бодлогын судалгааны төвийг /БСТ/ байгуулахаар шийдвэрлэсэн билээ. Аливаа улс орон ухаалаг, зөв бодлого гаргахын тулд бодитой судалгаанд суурилах учиртай. Хэрэгжүүлсэн бодлогынхоо алдаа, оноонд нөлөөллийн дүн шинжилгээ хийж, сургамж авч, боловсронгуй болгон урагшлах учиртай. Мөн шинээр хэрэгжүүлэх бодлогоо боловсруулахдаа судалгаанд түшиглэсэн урьдчилсан тооцоо, мэргэжлийн зөвлөмжийг харгалзах ёстой. Бодлогын судалгааны үндсэн зорилго үүнд оршино.

Улс орноо зөв удирдан чиглүүлэх эрхэм чухал үйл хэрэгт эрдэм шинжилгээний байгууллагууд гол тулгуур багана нь билээ. МУИС бодлогын судалгааг хөгжүүлж, сургалттай хослуулснаар ирээдүйн мэргэжилтнүүд маань өнөөгийн бодлогод дүн шинжилгээ хийх дадал, чадварыг эзэмшиж, ирээдүйд бэлтгэгдсэн мэргэжилтнүүд болж төгсөн гарах болно.

МУИС бодлогын судалгааг хөгжүүлэх зорилгоор энэхүү төвийг байгуулахдаа эхлээд Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийнхаа дэргэд зохион байгуулж, Монгол Улсын нэр хүндтэй судлаач, дипломатч, мэргэжилтнүүдийг урин цуглуулж, их эрдмийн эргүүлэг, номын далайг үүсгэж байгаа билээ. Улмаар энэ төв хоёр жилийн дараагаас цар хүрээгээ нийт МУИС-ийн хэмжээнд болгон өргөжүүлж, Монгол Улс дахь бодлогын судалгааны цөм болох алсын хараатай юм.

БСТ-ийн гол үйл ажиллагаа бол улс төр, нийгмийн амьдралын салбарууд дахь бодлогын чухал сэдвээр судалгааны төсөл хэрэгжүүлж, үр дүнгээ холбогдох байгууллагуудад зөвлөмж болгон өгөх юм. Үүний зэрэгцээ БСТ сар тутам гол бодлого, үйл явдалд дүн шинжилгээ хийсэн мэдээ, мэдээлэлтэй бюллетень гаргаж, тодорхой хүрээнд, мөн олон нийтэд түгээн хүртээж байх болно. Энэхүү бюллетений анхны дугаарыг гардан авч уншиж буй эрхэм уншигч танд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Бодлогын судалгааны төвийнхөө цаашдын ажил үйлсэд амжилт хүсээд, эрдмийн ариун зам нь дардан байхыг ерөөе.

Б.Болдгив

*МУИС-ийн Эрдэм шинжилгээ, инновац,
гадаад харилцааны асуудал эрхэлсэн дэд захирал*

2016 оны 12 дугаар сар.



Сүхээгийн Баттулга

МУИС-ийн ОУХНУС-ийн захирал, доктор
(PhD), профессор

Бид хамтдаа бодлогын судалгааг хөгжүүлнэ

Монголын нийгэмд өөрчлөн байгуулалт өрнөж эхлээд байсан 1991 онд МУИС бүрэлдэхүүндээ “Олон улсын харилцаа” нэртэй сургууль байгуулах шийдвэр гаргаснаар Монгол Улс өөрийн нөөц бололцоондоо тулгуурлан их сургуулийн түвшинд гадаад харилцааны мэргэжилтэнг бэлдэж эхэлсэн билээ. Тус сургууль энэ хугацаанд гадаад харилцаа, орон судлалын 2000 гаруй мэргэжилтэнг бэлдсэн бөгөөд тэдний түүрүүч нь УИХ-ын гишүүн, Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдын түвшинд хүрчээ. Ийнхүү “Харилцаа” гэх боловсролын бренд бий болж, үндэсний хэмжээнд гадаад харилцааны мэргэжилтэнг бэлдэх бааз суурь багтай тогтжээ. МУИС 2011 онд бүтцийн өөрчлөлт хийх шийдвэр гаргаж, тус сургууль “Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль” болон өргөжлөө.

МУИС 2011 онд хөгжлийн шинэ стратеги чиглэлээ тодорхойлж, өрсөлдөхүйц чадавхитай “судалгааны их сургууль” болох зорилт дэвшүүлээ. Энэхүү зорилтын хүрээнд сургалт судалгааг чанарын өндөр түвшинд зохион байгуулах, өрсөлдөхүйц, хөрвөх чадвартай боловсон хүчнийг бэлдэх, олон улсын харилцаа, бүс нутаг, хөгжлийн бодлогын судлаачдын залуу халааг мэргэшүүлэн бэлдэх, төгсөгчдөө тасралтгүй хөгжүүлэх, олон талт, салбар дундын судалгааг хөгжүүлэх шаардлага өнөөдөр бидэнд тулгарч

байна. Мөн түүнчлэн “шилэгдмэл” монгол дипломатч, стратеги төлөвлөгч, удирдагч нэгдсэн бодлого, системийн хүрээнд тодорхой шат дамжлага, сорилтуудыг даван бэлтгэгдэж, түүний дундаас шилэгдэж, товойн гарч ирэхүйц зохистой орчин, нөхцлийг бүрдүүлэх, тэрхүү үйл ажиллагаанд идэвхтэй оролцох хэрэгцээ бидэнд байна.

ОУХНУС дээрх бодлого, төлөвлөлтийн дагуу ойрын болон дундын хугацаанд өндөр түвшний судалгаанд онцгой анхаарч, ахисан түвшний, академик сургалтыг хөгжүүлэхийн зэрэгцээ олон улсын харилцаа, удирдлагын мэргэшсэн сургууль болж, бүс нутагтаа үнэлэгдэхүйц боловсон хүчнийг бүрдүүлэх зорилт дэвшүүлж байгаа юм. Үүний тулд бид:

Бодлогын хувьд: Монгол улсын хөгжлийн чиг хандлагатай уялдаатай, үндэстний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлалын үндсэн зарчимд тулгуурласан, глобал, нээлттэй, тогтвортой, хөгжлийн төлөө, нийгмийн хариуцлагатай, сургалт судалгаа нь цогц, академик эрх чөлөөгөөр хангагдахуйц байх.

Судалгааны хувьд: Судалгааг үндэсний эрх ашиг, хөгжлийн бодлоготой уялдуулах, шинжлэх ухаанч, салбар дундын, нээлттэй болгон хөгжүүлэх, үндэсний эрх ашигт нийцсэн судалгааны хамтын

ажиллагааг дэмжих, туршлагатай, шалгарсан судлаач, мэргэжилтнийг татан ажиллуулах нөхцөл боломжийг бүрдүүлэхээр төлөвлөж байна.

Манай сургуулийг түшиглэн ажлыг нь эхлүүлж буй Бодлогын судалгааны төв дээрх зорилгод хүрэхэд онцгой ач холбогдолтой гэж бид үзэж байна. Энэхүү Бодлогын судалгааны төвөөр дамжуулан судлаач эрдэмтдийн хуйлралыг үүсгэж, түүний үр дүнд эрдэмтэн судлаачид олон хэлбэрээр нэгдэн хамтран ажиллах орчин бий болж, улс үндэстний ашиг сонирхолд нийцсэн өндөр түвшний судалгаа хөгжиж, улмаар бодлогын судалгаанд тулгуурлан Монгол улсын хөгжлийн шинэ загвар дэлхийд хүлээн зөвшөөрөгдөхийг хүсэн хүлээж байна.

Бодлогын судалгааны төвийг байгуулах ажилд үнэтэй хувь нэмэр оруулж буй Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, доктор Х.Бэхбат тэргүүтэй багийнхан, УТА-ийн дэд захирал О.Машбат, УИХ-ын гишүүн асан М.Батчимэг, дипломатч доктор Ж.Энхсайхан, Ж.Гөлгөө, судлаач Б.Индра нарт гүн талархал илэрхийлэхийн ялдамд Эрхэм уншигч та бүхэндээ тус сургуулийн 25 жилийн ойн баярын мэнд дэвшүүлж, сайн сайхныг хүсэн ерөөе. Монгол үндэстний эрдэм оюун улам бүр хурцлагдах болтугай.

МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн дэргэд шинэ тутам байгуулагдаж буй Бодлогын судалгааны төв өнгөрсөн 9 дүгээр сараас эхлэн судалгааны хоёр төсөл хэрэгжүүлж байна. Нэг нь “Гадаад бодлогын шийдвэр гаргах механизмыг боловсронгуй болгох нь” сэдэвтэй бөгөөд Элчин сайд, доктор Ж.Энхсайхан уг судалгааны багийг удирдан ажиллаж байна. Хоёр дахь нь “Гурван улсын эдийн засгийн коридорыг Монгол улсын гео-эдийн засгийн сонирхолтой уялдуулах нь” сэдэвтэй, доктор Ж.Гөлгөө тэргүүлэн ажиллаж буй. Энэ хоёр сэдэв хожуула манай улсын хувьд чухал ач холбогдолтой, нэн тулгамдсан асуудлууд гэдэг нь ойлгомжтой билээ.

Эдгээр бодлогын судалгааны ажлууд 12 дугаар сарын дундуур дуусч холбогдох байгууллага, хүмүүсийн гар дээр очих учиртай. Гэвч манай “тогтмол хэвлэлийн” анхны дугаар гарч буйг ашиглан уншигч олондоо учиг утгаас нь товчхон ч атугай танилцуулах нь зүйтэй болов уу хэмээн судлаачиддаа хандсан юм. Болгоох ажаамуу.

Бодлогын судалгааны төвийн дарга Х.Бэхбат

Л.Удвал

МУИС-ийн ОУХНУС-ийн Бодлогын судалгааны төвөөс

хэрэгжүүлж буй “Гадаад бодлогын шийдвэр гаргах механизмыг боловсронгуй болгох нь” төслийн багийн гишүүн, ОББЭЭС

Гадаад харилцаанд оролцогчдын буюу “тоглогчдын” тоо эрс нэмэгдэж, зорилт болон асуудлуудын агуулга, хүрээ тэлсээр байгаа өнөөгийн нөхцөлд гадаад бодлогын шийдвэр гаргах механизмын үүрэг өсч, бодлого зохицуулалтын асуудал нэн чухал болж байна.

Гадаад бодлогын зохицуулалт нь онолын хувьд үйл ажиллагааны зохицуулалттай адил зүйл гэж үзэж болохоор юм. 1990-ээд оноос онол зүйн хувьд нийгмийн шинжлэх ухааны шинэ салбар болон хөгжиж буй бодлого зохицуулах ухаан чухамдаа үйл ажиллагааны хоорондын хамаарлыг шийдэх арга хэрэгсэл юм. Тодорхой зорилго өмнөө тавьсан, бие даасан оролцогчид үйл ажиллагаагаа явуулахдаа хоорондын зөрчил болон уялдаа холбоог нэгдсэн буюу хамтын зорилгод хүрэх үүднээс зохицуулах зайлшгүй шаардлагатай тулгардаг. Энд нэг талаас зөрчил, нөгөө талаас уялдаа холбоо гэсэн харилцаа үүсэх бөгөөд үүнийг нь өргөн утгаар авч үзвэл чухамдаа харилцан хамаарал юм.

Энэ нь нэг талаар гадаад бодлогод “оролцон тоглогчдын” дотоод тогтолцооноос хамааралтай байж болох бөгөөд нөгөө талаар дэвшүүлсэн зорилгодоо хүрэх үйл ажиллагааны төлөвлөгөө, оролцогчдын хооронд үүрэг хариуцлага, санхүүгийн ба хүний нөөцийн хамгийн зохистой хуваарилалт бүрдсэн эсэх болон, тэр нь хэр оновчтой бөгөөд зөв хэрэгжиж байгаа эсэх зэрэг асуудалтай холбоотой байх нь олонтаа. Анзаарваас хариуцлагын тогтолцооны механизм хэр зэрэг тавигдсан, хэрэгжилт нь ямар байгаа болон хариуцлага хүлээх ухамсар, соёл хэр зэрэг хөгжсөн зэрэгтэй ч бас холбоотой ажээ.

Монгол Улсын гадаад бодлогын зохицуулалт, шийдвэр гаргалт болон энэ хүрээнд үйлчилж буй харилцан хамаарлын байдлыг авч үзвээс хуулиараа гадаад бодлого, үйл ажиллагааны үндсэн зохицуулагчийн хувьд ГХЯ дотоодын олон “тоглогчийн” тогтолцооны болон зохион байгуулалтын чанартай зөрчил хийгээд уялдаа холбооноос үүдэлтэй хамаарлыг “нэг цонхоор” харж, зангидан зохицуулах үүрэгтэй юм.

Монгол Улсын гадаад бодлогын шийдвэр гаргах механизмыг боловсронгуй болгох шаардлага

ГХЯ энэхүү үүргээ Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Засгийн газрын тухай хууль, УИХ-ын тухай хууль, ҮАБЗ-ийн тухай хууль болон Засгийн газрын мөрийн хөтөлбөр, УИХ, ЗГ, ҮАБЗ-өөс гаргасан тогтоол шийдвэр, зөвлөмжүүдэд нийцүүлэн хэрэгжүүлэх ёстой.

Гэвч бэлхнээ байгаа эрх зүйн орчны хүрээнд явуулах учиртай үйл ажиллагаа зарим талаар доголдож, шийдвэр гаргах механизм алдагдаж байна. Энэ тухайд гадаад бодлогын хэрэгжилтэд зохих үүрэгтэй оролцдог бүтцүүд төдийгүй монголын нийгэм бүхэлдээ ямар нэгэн хэмжээгээр шүүмжлэн ярьж, улмаар нэн даруй засч залруулах нь зүйтэй гэж үзэх болсон байна.

Ер нь гадаад бодлогын шийдвэр гаргах механизмын хувьд хууль тогтоомж, эрх зүйн боломжийн орчин бүрдсэн байна гэж үзэхээр байгаа юм. Харин эдгээр хууль тогтоомжуудад бэлхнээ заасан хариуцлагын тогтолцооны механизм үйлчлэхгүй байгаа буюу үйлчлэх боломж нь зарим талаар хаалттай байгаа нь уг механизмыг сулруулах, улмаар гажуудуулах шалтгаан болж байна уу гэлтэй.

Яагаад ийм байдал буй болов?

- Төрийн, түүний дотор гадаад бодлогын үйл ажиллагаанд сайнгүй нөлөөлж байгаа нэг хүчин зүйл нь улс төрийн намууд төрийн тогтолцоо, эрх мэдэл, үйл ажиллагаанд хэтэрхий оролцон нөлөөлөх болсон явдал гэж үзэхээр байгаа

- Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор заан тодорхойлсон эрх мэдэл, ялангуяа түүний хэм хэмжээ алдагдах тохиолдол ажиглагдаж буй
- хууль тогтоомжоор бэлхнээ зохицуулсан хариуцлагын тогтолцооны механизм тэр бүр сайн ажиллахгүй байгаа
- гадаад харилцааны бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэгч төрийн төв байгууллага болох ГХЯ-ны дуу хоолой зохих ёсоор сонсогдохгүй, эсвэл түүнийг санаатайгаар орхигдуулж, заримдаа бүр түүнийг алгасан асуудлыг шийдэх арга хайх тохиолдол ч гарах болсон,
- түүнээс улбаалан дурын байгууллага, албан тушаалтан өөрийн эрх мэдлээр гадаад бодлогын холбогдолтой шийдвэр гаргах тохиолдол цөөнгүй гарч, нэгдсэн бодлого, нэгдмэл зохицуулалт ихээхэн сулрахад хүрсэн
- асуудалд үндэсний нэгдмэл эрх ашгийн үүднээс хандахаасаа субъектив хүчин зүйлс, тухайлбал улс төрийн болон эдийн засгийн явцуу бүлгийн эрх ашиг, заримдаа бүр хувь улс төрчдийн дур зорго, хүсэл сонирхолд ч хөтлөгдөх шинжтэй болсон
- шийдвэр гаргахдаа нарийвчилсан судалгаа гаргах, түүнийхээ үндсэн дээр ул суурьтай дүн шинжилгээ хийх, салбарын эрдэмтэн мэргэжилтний дуу хоолойг сонсох явдал дутмаг байгаа
- төрийн албанд ажиллагсдын хуулийн ухамсар, ёс зүй дорой, хариуцлага хүлээх чадвар сул байгаа төдийгүй тэднийг соён гэгээрүүлэх, эрдэмжүүлэх, аливаа алдаа эндэгдэл гаргахаас урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй байгаа зэргээс шалтгаалж байна гэж үзүүштэй.

Нөгөөтэйгүүр, ГХЯ-ны зүгээс нэгдсэн бодлогоор хангах, гадаад харилцааны үйл ажиллагаанд оролцогсдын хамаарлыг зохицуулах, зангидан чиглүүлж удирдахад мөн цөөнгүй хүчин зүйл нөлөөлж байна гэж үзэхээр байгаа юм. Эдгээр хүчин зүйл болон уг механизмыг хэрхэн боловсронгуй болгох талаарх санаа оноог дараачийн дугаараас сонирхоно буй заа.

үргэлжлэл 8-р нүүрэнд



С.Баясгалан

МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн докторант

АНУ-ын сонгууль ба дэлхийн дэг журам

Саяхан болтол дэлхий нийтээрээ АНУ-ын гадаад бодлогын чиг шугамыг Хоёрдугаар дайнаас хойш өөрчлөгдөхгүй энэ хэвээрээ байна гэсэн ойлголттой байв. Тэр дундаа АНУ-ын холбоотон улсууд түүний хамгаалалтан дор, ямар нэгэн үүрэг хүлээхгүйгээр аюулгүй байдлаа баталгаажуулсан хэвээр байна гэсэн ойлголттой явж иржээ. Гэвч Хоёрдугаар дайнаас хойш бий болсон өнөөгийн дэлхийн систем тодорхой сорилтуудтай тулгарч байгааг АНУ-д болсон сонгууль харуулав. Америкийн сонгууль нь Баруун буюу Өрнөд (West) хэмээх иргэншлийн бий болгосон өнөөгийн систем (либерал ардчилсан) энэ хэвээрээ байгаа болж, тодорхой өөрчлөлт орохоор байгааг ч бас харуулав.

АНУ-ын сонгуулийн үр дүн хэн ч ил ярьдаггүй боловч бүгд мэддэг АНУ-д тулгарч буй асуудлууд болох хээл хахуульд идэгдсэн улс төрчдийн (элит) давхрага, Дээд шүүхийн шудрага бус байдал, хуулийн байгууллага сонгуульд нөлөө үзүүлэхээр оролцож байгаа, хэсэг цөөн хүмүүс баялгийг өөртөө төвлөрүүлж байгаа, гадны цагаачид америк иргэдийн ажлын байрыг “булааж” байгаа зэрэг өнөөдөр үүсчихсэн биш, явц дунд бий болж тулгамдсан асуудлуудыг ил гаргав. Гэхдээ энэ үйл явц нь Сирийн хямралаас хойш Европт бий болсон дүрвэгсэдийн асуудлаар эхэлчихсэн байсан ба АНУ-ын сонгуульд Д.Трампа ялснаар эргэлт буцалтгүй болж байна.

АНУ-ын сонгуультай холбогдон 2017 онд Европын холбооны орнуудад болох сонгуульд баруун төвийн, уламжлалт буюу консерватив чиг баримжаатай хүчнүүд түлхүү ялалт байгуулвал гайхах зүйлгүй болоод байна. Тэр тусмаа Их Британийг Европоос гаргахын төлөө (Brexit) идэвхтэй явж байсан улс төрч Нигел Farage “хэдийгээр Британичууд АНУ-ын сонгуультай төстэй Brexit-ийг хийсэн боловч Д.Трампын ялалт Brexit-ээс илүү “улс төрийн хувьсгал хийв” гэж хэлсэн нь уур амьсгал ямар

хэмжээнд байгааг харуулж байна.

Нөгөө талаар АНУ хүчтэй удирдагчийг хүсэж байлаа. Ялангуяа Б.Обама зэрэг өмнөх Ерөнхийлөгч нар нь ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин шиг хүчтэй шийдэмгий байж чадаагүй нь дэлхий нийтэд АНУ-ыг ОХУ-ын өмнө сул дорой харагдуулж байна гэж үзэв. Ийм ч учраас Д.Трампын АНУ-ыг дахин хүчтэй болгох тухай уриаг америкчууд дэмжсэн нь харагдаж байна.

Либерализмыг түүчээлэн явж, ардчилал, хүний эрхийг дээдэлсэн улс орнуудад төдийгүй дэлхийн бусад оронд ч үлгэр жишээ болж байгаа АНУ өөрөө бодлогоо уламжлалт, реалист хандлага руу чиглүүлж байна.

Энэ бүх нөхцөл байдлаас үүдэн АНУ-ын ард иргэд шинэ ерөнхийлөгчийг сонгохын зэрэгцээ дэлхийн шинэ дэг журамд нөлөө үзүүлэх сонголт хийв.

Америкийн сонгуулийн үр дүнг сонсоод Европын Холбооны болон бусад улс орны либерал чиг баримжаатай дээд удирдлагууд цочролд орсноо нуугаагүй юм. Тухайлбал Европын Холбооны комиссын Ерөнхийлөгч Дональд Таск “АНУ-ын сонгууль трансатлантын харилцаанд сорилт авчирлаа” хэмээн мэдэгдсэн байхад Германы Канцлер Ангела Меркель “Герман болон АНУ үнэт зүйлсээрээ холбоотой: ардчилал, эрх чөлөө, эрх зүйт нийгэм, хүн төрөлхтний бахархал, угсаа гарвал, арьсны өнгө, шашин шүтлэг, хүйс, бэлгийн цөөнх, улс төрийн үзэл бодлоос үл хамаарах байдал. Энэ бүхнээр АНУ-ын шинэ Ерөнхийлөгч Д.Трампа нямт хамтран ажиллах саналтай” байгаагаа илэрхийлснээс нь үзэхэд өөрсдийн үнэт зүйлээ алдахаас болгоомжилж байна

гэлтэй. Тэр ч бүү хэл Германы батлан хамгаалахын сайд Урсула фон дэр Лээн АНУ-ын сонгуулийн үр дүнд 1945 оноос хойш олон улсын харилцааны суурь болсон Пакс американа асуудалд орж байна гэжээ¹.

Д.Трампа ялснаар дэлхийн дэг журам либерал ардчиллаас национализм руу орж байна гэж Барууны эрдэмтэд үзэж байгаа боловч олон улсын харилцааны реализмын чиг шугам руу шилжиж байна гэж үзэх нь зөв юм. Либерал гэдгийн дор угтаа чөлөөт худалдаа, хөрөнгө оруулалтыг ойлгодог байсан бол энэхүү ойлголт хүрэнээсээ хальж эдүгээ нэг дэлхий, нэг үндэстэн, даяаршил, соёлын нэгдэл, хавтгай дэлхий гэх мэт ойлголт руу хальтран орсон байна. Үүний сул тал нь хөгжилтэй орнуудын ажлын байр хумигдаж, зах зээлийн өрсөлдөөнөөс болоод компаниуд ажлын байраа цомхотгож, товчоор элитүүдийн бий болгосон систем зах зээлийг либералчилсан, эдгээр нь элитүүдэд ашгаа өгөхөөс бус энгийн иргэд улам ядуурсан гэж үздэг. Үүний зэрэгцээ үндэстэн улсын бүрэн эрхийн асуудал, соёлын үнэт зүйлд хүртэл сорилт тулгарчээ.

Д.Трампа консерватив чиглэлийн байр суурь баримталдаг хүний хувьд эдийн засгийн болон олон улсын харилцааны тогтолцооны хувьд улс орноо хүчирхэгжүүлэх, америкчуудыг ажилтай болгох, дотоодын үйлдвэрээ дэмжих амлалт өгсөн. Энэ хүрээнд чөлөөт худалдааны байгууллагуудаас гарахаа зарлаж, АНУ-ын холбоотнуудыг тэрээр АНУ-ын хүчинд үнэгүй дулдуйдахаа больж өөрсдийн зүгээс хувь нэмэр оруулах ёстой гэж үзэн тэднийг болзолтойгоор буюу төсвийн тодорхой хувь нэмэр оруулах замаар холбоотон хэвээр байх асуудал сөхсөн нь олон улсын харилцаанд ихээхэн өөрчлөлт гарах хандлагатай болгож байгаа төдийгүй бүс нутгийн хүчний тэнцвэрт нөлөөлж болзошгүй байна.

¹ <http://www.theglobeandmail.com/news/world/us-election-with-trump-americans-voted-in-a-new-world-order/article32754120/>



Б.Индра

МУИС-ийн Олон улсын харилцаа,
нийтийн удирдлагын сургуулийн
Бодлогын судалгааны төвийн судлаач

Орос, Хятад зүтгүүртэй бүс нутгийн интеграци

“Хятадын Ерөнхий сайд Ли Көчян 11 дүгээр сарын 6-аас 8-нд ОХУ-д айлчилж, 21 дэх удаагийн Хятад, Оросын ерөнхий сайд нарын тогтмол уулзалтад оролцох үеэр хамтын ажиллагааны 20 гаруй санамж бичигт гарын үсэг зурж, “Хамтарсан мэдэгдэл” гаргасан билээ. Ли Көчяны айлчлалаар тохиролцсон зүйлээс анхаарал татах заримыг нь энд онцлоё.

Глобал түвшинд Орос, Хятадын ашиг сонирхол сайтар нэгддэг, энэ бол АНУ-ын “жанжлал”-ын эсрэг “жамаараа” яваа “үерхэл” билээ. Энэ удаагийн хамтарсан мэдэгдэлдээ ч талууд АНУ-ын эдийн засгийн бодлогыг шүүмжилж, “хаалттай худалдааны холбоо байгуулах, дангаараа хориг тавих, янз бүрийн хязгаарласан механизм ашиглах явдал дэлхийн эдийн засагт таагүй хүчин зүйл болж байна” гээд, үүнийг саармагжуулахын тулд ОХУ, Хятад хоёр “хөгжиж буй болон сэргэн мандаж буй том эдийн засгуудын төлөөлөл, жин нөлөөг улам нэмэх ёстой” гэж айлдсаны зэрэгцээ “дэлхийн эдийн засагт инноваци, бүтцийн шинжтэй өөрчлөлт хийхэд хоёр тал зохицуулалтаа сайжруулна” хэмээн хамтын арга замаа дурджээ. Энэ бол глобал түвшинд авах арга хэмжээ.

Бүс нутгийн түвшинд, ОХУ, Хятад хоёр “худалдааны гадаад таагүй хүчин зүйлийг бууруулах гол гарц бол бүс нутгийн интеграци”, тодруулбал “Евразийн эх газарт эдийн засгийн түншлэлийн замаар интеграцийг гүнзгийрүүлнэ” гэсэн нь Хятадын “Нэг бүс нэг зам”, Оросын “Евразийн эдийн засгийн холбоо” хоёрыг (хэдийгээр эд бүс нутагт халз тулгарч байгаа ч) аль болох зөрчилдүүлэхгүй байх сонирхол аль алинд нь байгааг илтгэнэ. Хамтарсан тунхаглалд ингэж зааснаас харахад дэлхийн эдийн засагт барууны орнуудын явуулж буй бодлого Орос, Хятадын стратегийн ашиг сонирхлыг улам ойртоход хүргэсэн гэж болно. Нэг ёсондоо бүс нутагт өрсөлдөх ёстой стратегиуд атал харин ч угталцан хөгжихөд, гадаад хөшүүрэг л тэгж нөлөөлж чадах биз ээ. Гэхдээ энэ бүс нутгийн интеграцид Хятадууд давамгайлж мэдэх юм. Учир нь “Орос, Хятадын хамтын ажиллагаанд Хятадууд эдийн засгийн салбарыг хариуцаж буй, тухайлбал Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк, ШХАБ-ын хөгжил зэрэг. Харин ОХУ цэргийн аюулгүй байдлыг хариуцаж буй, тухайлбал цэргийн бааз, зэвсгийн худалдаа

зэргийг хангадаг” хэмээн Карнегийн төвийн судлаач Александр Габуевийн хэлсэнчлэн “Хэрвээ Хятад банк нь бол Орос зэвсэг нь юм”.

Ли Көчяны айлчлалаас бидэнд илүү хүртээлтэй асуудал нь юу байв гэхээр

Д.Медведев, Ли Көчян нарын гаргасан хамтарсан мэдэгдэлд “Орос, Монгол, Хятад гурван улсын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг урагшлуулна хэмээжээ.

Түүнчлэн “Алс Дорнодын бүс нутагт хөрөнгө оруулах Хятадын сонирхлыг Орос дэмжих”-ээр барахгүй “Хятадын Зүүн хойд бүс, Оросын Алс Дорнодын болон Байгалийн бүсийн орон нутгийн засаг захиргаа хоорондын Хамтын ажиллагааны зөвлөл байгуулах”-аар шийджээ. Хятадын “Нэг бүс нэг зам” санаачилга дахь эдийн засгийн 6 коридорын нэг болох “Умард коридор” нь хоёр маршруттай бөгөөд нэг нь Монголоор, нөгөө нь Манжуураар дайрч байгаа билээ.

Бид Манжуурын маршрутыг өрсөлдөгч гэж үзвэл манай маршрут газрын дөт гэдгээс өөр давуу тал маруухан болж байна. Тиймээс аюулгүй, найдвартай, шуурхай гэх мэт софт давуу талыг бид яаралтай бий болгох шаардлагатай байгааг жил ирэх бүр зузаарч буй Орос, Хятадын харилцаа сануулж байна.

Ли Көчяны ОХУ дахь айлчлалын үр дүнг хятадын Орос судлаач Дин Шяошин дүгнэхдээ, хоёр талын харилцаа өндөр түвшинд хөгжиж буйгаас гадна Хятадтай ийн нягтарч буй нь Оросын гадаад бодлогын өөрчлөлтийн нэг илрэл гэжээ. Түүнчлэн хятадын экспертууд энэ удаагийн айлчлалыг маш бодитой, прагматик гэж үнэлсэн байна. Учир нь талууд дэд бүтцийн салбарт Москвагаас Казань хүрэх 700 гаруй км хурдны галт тэрэг барих төслийг шуурхайлахаар болов. Худалдаа, хөрөнгө оруулалтад аль болох өөрсдийн мөнгөн тэмдэгтээ ашиглахыг дэмжихээр тохиролцов. 2020 он гэхэд харилцан суралцагчдын тоог 100 мянгад хүргэнэ гэх мэтээс гадна

сансарын технологи, интернэт болон “ногоон” технологийн салбарт зузаарч байгаа ажээ.

Хэдийгээр Орос, Хятадын харилцаа ийн зузаарч байгаа боловч тийм ч шулуун дардан бас биш. Хятад, Орос хоёр улс төрийн салбарт асар нягт харилцаатай атал эдийн засгийн хамтын ажиллагаа нь санасанчлан биш байгааг 2015 онд буурсан хоёр талын худалдааны хэмжээнээс харж болно. Зэвсэг техникийн салбарт хэдий хамтарч ажилладаг ч Хятад улс зэвсгийн зах зээлд Оросын өрсөлдөгч болсоор байгаа. Байгалийн хий нийлүүлэх наймаа олон жил сунжирч байгаад 2018 оноос 30 жилийн турш нийлүүлэхээр тохиролцоонд хүрсэн нь Оросын эдийн засгийн байдал хүндэрсэнтэй холбоотой хийсэн буултын үр дүн гэж болох юм. Хятадын “Нэг бүс нэг зам” стратеги Төв Азид эдийн засаг, аюулгүй байдлын хэлхээг нь бэхжүүлнэ. “Экономист” сэтгүүлд бичсэнчлэн Хятадтай харилцах харилцаанд Оросууд улам бүр үлбэгэр дүрд тоглож байгаадаа бачимдаж байгаа, Оросын хувьд Хятадтай түншлэх нь шаналгаатай боловч яалт ч үгүй шаардлагатай зүйл, харин Хятадын хувьд Оростой сайн харилцаатай байвал сайн л хэрэг, үгүй бол тэр л биз гэх маягтай.

Д.Трампа АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдсоны дараа Орос, АНУ-ын харилцаа зөөлрөх хандлагатай байгаа нь Орос, Хятадын харилцаанд нөлөөлөх эсэх талаар Хятадын албаны сайтад бичихдээ “Орос, Хятадын харилцаа урт удаан бүрэлдэж ирсэн, энэ харилцаа Оросод зөв зүйтэй зүйл, үүнийг ОХУ ямар нэг зүйлээр дэнчин тавьж арилжин байж бий болгоогүй, тийм болохоор Орос АНУ-тай харилцаагаа хөгжүүлэхийн тулд Хятадтай харилцах харилцаагаа золиослох ямар ч шаардлага байхгүй. Хятад, АНУ, Оросын гурвалжин үндсэндээ хүчний нөхцлөөр шийдэгддэг. Гурвалжин дотроо АНУ хамгийн хүчтэй, стратегийн довтлогч учраас Хятад, Орос хоёр улам нягтрах нь ерөөс олон улсын улс төрийн логик. Нөгөө талаар Хятад, Оросын харилцаа сайн байх тусмаа аль аль нь АНУ-тай харилцаагаа хөгжүүлэхээр идэвхийлэх болно. Их гүрнүүдийн харилцаа баригдал зүйл ихтэй, хатуу тогтмол хандлагатай байдаг учраас Д.Трампа их гүрнүүдийн харилцааг өөрчилж гэхэд магадгүй хүчин чармайлт, тэргүүлэх чиглэл зэрэгт л зохицуулалт хийхээс хэтрэхгүй, гол хандлагаас давж ажиллахад амаргүй л болов уу” хэмээжээ.



М.Батчимэг

МУИС-ийн ОУХНУС-ийн Бодлогын судалгааны төвийн зочин профессор
“Улаанбаатар” бодлогын судалгааны төвийн зөвлөх

Төр...

Дэлхий хаашаа явж байна вэ?

Хуанлийн хуудас эргэсээр саяхан дуу шуутай угтаж байсан 21-р зуун хоёр дахь арваныхаа төгсгөл рүү ойртож явна. Тэртээ 1980-аад оны дунд үеэс олон улсын хэмжээнд эрчээ авсан ардчилал, неолиберализмын хүчтэй давалгаа оргил үеэ аль хэдийнээ үджээ.

Монгол зэрэг хуучин социалист орнуудад улс төрийн ардчилсан тогтолцоог төлөвшүүлэх хүчин чармайлт тийм ч амар байсангүй. Дарангуйлагч улс төрийн дэглэмийг халж, хүний эрх, эрх чөлөөг үнэт зүйл болгосон нийгмийн шинэ харилцаа, хувийн өмч, хувь хүний бизнесийн эрх чөлөөг хүлээн зөвшөөрсөн зах зээлийн эдийн засгийг төлөвшүүлэх замд багагүй амжилт олсон ч дийлэнх пост коммунист орны иргэд өнөөдрийн байдалдаа сэтгэл дундуур, Унгар, Украйнаас эхлээд зарим улс оронд ардчиллаас ухарсан ухралт, олон нийтийн зүгээс ардчилсан тогтолцоонд үл итгэх байдал илэрхий болсоор байна.

Зөвхөн хуучин социалист орнуудад төдийгүй ардчилал, зах зээлийн үлгэр дуурайл гэгддэг өрнөдийн ардчилсан орнуудад тулгарч байгаа сорилтууд АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа улам ил боллоо. Сүүлийн нэг хоёр жилийн хугацаанд ар араасаа өрнөсөн Евро Парламентын сонгуульд үндэсний үзэлтэй, экстремист чиг хандлагатай намууд олноороо суудал авсан, Их Британийн иргэд Европын холбооноос гарах шийдвэр гаргасан, Германы орон нутгийн сонгуульд канцлер Меркелийн нам ялагдаж хэт туйлширсан үндсэрхэг барууны үзэлтэй нам амжилт олж эхэлсэн зэрэг үйл явдлууд өөрчлөгдөн буй дэлхий ертөнцийн хандлагыг аажмаар мэдрүүлсээр байсан гэж хэлж болно.

Энэ бүх үйл явдлын дараа АНУ-ын сонгуульд тус улсын цэрэг, аюулгүй байдлын салбарт дэлхий дахинаа гүйцэтгэж байгаа үүргийг хумих, Ази Номхон далайн бүс нутагт Америк төвтэй олон улсын чөлөөт худалдааны дэглэм буй болгох хүчин чармайлтыг зогсоох, олон улсын тавцан дахь хэт идэвхтэй байр сууринаас ухарч протекционист бодлого явуулах байр суурьтай Дональд Трамп ялалт байгуулсан нь өрнөдийн ертөнцийг төдийгүй дэлхий нийтийг цочролд оруулсан үйл явдал боллоо.

Хурдтай өөрчлөгдөж буй ийм шинэ нөхцөл байдалд “АНУ-ын дэлхийд тэргүүлэгч байр суурь юу болох вэ? Тус улс гадаад улс төрийн бодлогодоо ухралт хийж, эдийн засгийн протекционист бодлого дэлхий нийтийн хэмжээнд үүсч болзошгүй хүчний шинэ орон зайд ямар улс төрийн тоглогчид тодрох вэ? Европын холбооны гол ачааг үүрч, бодлогыг тодорхойлж байгаа, нэгдмэл Европын төлөө байр суурьтай Германы эрх баригч нам ирэх жил болох сонгуульд тэсч үлдэх үү? Хэрэв Меркелийн нам ялагдавал Европын холбоо бүтэн үлдэх үү? Франц улс Европын холбооноос

гарах уу? НАТО-гийн ачааг хэн үүрэх вэ? Их гүрнүүдийн цэрэг-улс төрийн харилцааны шинэ тэнцвэр хэрхэн тогтох вэ? Бреттон Вүүдсийн систем буюу АНУ төвтэй Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн банк санхүүгийн тогтолцоо тэсч үлдэх үү? Дэлхийн худалдааны байгууллагыг ямар ирээдүй хүлээж байна вэ? Дэлхийн улс төрийн хүндийн төв Евроазид шилжих үү? Хятад – Оросын хамтын ажиллагаанд түшиглэсэн, шинэ торгоны замаар Евроазийг холбосон эдийн засгийн хүчирхэг шинэ төв үүсэх үү? Юань олон улсын гол валют болох уу?” гэх мэт олон асуулт дэлхий нийтийн өмнө ар араасаа хөвөрч эхэллээ. Яг өнөөдөртөө, магадгүй ойрын богино хугацаанд эдгээр асуултын хариуг яг таг хэлчих улс орон, улс төрч тун цөөн байх биз ээ. 1989 оны 12 дугаар сард болсон хүйтэн дайны түүхэн төгсгөл - Берлиний хана нуран унасан домогт үйл явдлыг урьдчилж харсан хүн бараг байгаагүйтэй адил. Товчоор хэлэхэд дэлхий нийт өнөөдөр тодорхойгүй нөхцөл байдлын өмнө, түүхийнхээ нэгэн эргэлтийн цэг дээр байна гэж хэлж болохоор байна.

Гэхдээ энэ бүхэн урьд тохиож байгаагүй шинэ зүйл, эсвэл нэгэн зүгт эргэлт буцалтгүй гарч байгаа өөрчлөлт биш гэдгийг баттай хэлж болно. Улс төрийн хувьд дэлхий нийтэд ардчилал хөгжиж, бас хумигдаж ирсэн, эдийн засгийн хувьд либерал болон төрийн оролцоо, зохицуулалтыг шүтсэн протекционист хэлбэрийн бодлого тодорхой мөчлөгтэйгээр ээлжлэн солигдож ирсэн, олон улсын харилцаа нээлттэй болох, буцаж хумигдах үйл явц ээлжилж, даяаршлын хамрах хүрээ, эрч хүч дээш доош савлаж ирснийг дэлхийн түүх харуулна. Хүн хэмээх амьтны төрөлх араншингаас шууд хамааралтай нийгмийн ийм өөрчлөлт, савлагаа цаашид ч тодорхой давтамжтайгаар байсаар байх нь ч дамжиггүй. Дэлхийд нэртэй

эрдэмтэн Францис Фукуяма ерэн оны их өөрчлөлтийн босгон дээр коммунизм төгсгөл болж, улс төрийн ардчилсан тогтолцоо, эдийн засгийн либерализм ялалт байгуулсныг тунхаглан “Түүхийн төгсгөл буюу сүүлчийн хүн” хэмээх алдарт өгүүлээ бичиж байсан. Тэгвэл түүх тийм ч амар төгсчихгүй ажээ.

Гагцхүү урьд хожид байгаагүй мэдээлэл, технологийн шинэ эринд улс төр, эдийн засгийн тогтолцооны өөрчлөлт, хөдөлгөөн хэрхэн явагдах вэ, дэлхийн нэг, хоёрдугаар дайн, хүйтэн дайн шиг их золиос амсахгүйгээр олон улсын харилцааны шинэ тэнцвэр тогтох уу, өнөөдөр буй болоод байгаа тогворгүй нөхцөл байдал хэр удаан үргэлжилж, түүний араас ямар хугацаанд үргэлжлэх, ямар өнгө төрхтэй олон улсын амьдралын хэв загвар буй болох вэ гэдэг асуултууд сонирхол тагна.

Тодорхойгүй мэт харагдах энэ нөхцөл байдлын дунд зарим тодорхой дүгнэлтийг зоригтойгоор хийж болохоор байна.

Юуны өмнө дэлхий нийтэд гарч байгаа энэ өөрчлөлтүүдийг өнгөрсөн хэдэн арван жилд эрчээ авсан даяаршлын нөлөөгөөр буй болсон буцах савлагаа гэж хэлж болно.

Даяаршил хүн төрөлхтний түүхэнд хэдэнтээ эрчээ авч, бас буцаж хумигдаж ирсэн байдаг. Өнгөрсөн хэдэн аравны турш мэдээлэл, технологийн огцом дэвшлийн нөлөөгөөр өмнөхөөс хавьгүй эрчтэй өрнөсөн даяаршлын үйл явц улс орнуудын хооронд төдийгүй улс орны дотоодод баян хоосны ялгаа гүнзгийрэхэд ихээхэн нөлөөлсөн. Мөн даяаршлын нөлөөгөөр улс орнуудын хил хязгаар бүдгэрч ирсэн нь нэг улс

үндэстэн, бус нутагт буй болсон хямрал нөгөө улс орны иргэдийн амьдралд шууд сөргөөр нөлөөлж, хяналтаас гарах үйл явц нэмэгдсэн. Даяаршлаас хожигч нь нийгэм дэх илүү мэдлэг, мэдээлэлтэй, хөрөнгийн хуримтлалтай цөөнх хэсэг болж, хохирогч нь дийлэнх олонх болсон жирийн иргэд олон нийт болж байгаатай маргах хүн үгүй.

Дэлхий хавтгай болж амьдралын хурд, өрсөлдөөн нэмэгдэж, цахим ертөнцөөр түгэх элдэв хар бараан голдуу мэдээллийн дарамт ихсэхийн хэрээр хүмүүсийн сэтгэлзүйд урьд өмнийн тайван амьдрал, төрийн зохицуулалт, хүчтэй лидерийг хүсэмжлэх үзэл газар авч байгаад гайхах зүйл үгүй.

Энэ бүхний дүнд олон улсын харилцаанд эргээд олон улсын байгууллага, төрийн бус субъектүүдээс илүүтэй ТӨР, ҮНДЭСТЭН - УЛС гол тоглогч нь болсон уламжлалт харилцаа, реалист үзэл хандлага давамгайлах өнгө аяс ажиглагдаж эхэллээ.

Төр төвтэй үзэл улс орнуудын дотоодод ч, улс хоорондын харилцаанд ч дахин сэргэх нь ээ.

Бид хаана байна вэ? Хаашаа явах вэ?

Өрнөж буй үйл явц монголчууд бидний амьдралд ч нөлөөлөх нь эргэлзээгүй. Юуны өмнө Монгол Улсыг хүрээлсэн улс төр – аюулгүй байдлын орчинд ямар өөрчлөлт гарах вэ гэдэг бидний нэн түрүүнд анхаарах асуудал.

Цаашилбал иргэдийн улс төрийн намуудад итгэх итгэл буурч, үүнийг дагаад ардчилалд, ардчилсан төрийн тогтолцоонд эргэлзэх эргэлзээ нэмэгдэж байгаа үед гадаад ертөнцөд гарч буй өөрчлөлт Монголын улс төрийн амьдрал, улс төрийн тогтолцооны төлөвшилд ямар нөлөө үзүүлэх вэ гэдэг дараагийн том асуудал.

Монгол Улс эдийн засгийн хувьд дэлхийг хамарсан эрэлт, нийлүүлтийн сүлжээ, худалдаа эдийн засгийн тогтолцоонд өргөн хүрээтэйгээр нэгдэж чадаагүй байгаа нь дэлхийн эдийн засагт томоохон өөрчлөлт хөдөлгөөн гарсан ч бид их хохирол амсахгүйгээр өнгөрч болох боломжийг зарим талаар олгож байна. Гэсэн ч нөгөө талаас манай улсын санхүү, эдийн засгийн салбарын хөгжил, төлөвшил Дэлхийн банк, Олон улсын валютын сан зэрэг олон улсын байгууллагын хамтын ажиллагаа, өнөөгийн дэлхийн санхүү эдийн засгийн тогтолцооны үр шимийг нэлээд хүртэж ирснийг энд тооцохгүй байхын аргагүй.

Бид ийм нөхцөл байдалд юу хийх ёстой вэ? Юу хийх боломжтой вэ?

Монгол Улс олон улсын хүчний тэнцвэр, дэлхийн дэг журмыг тогтооход нөлөөлдөг хүчтэй тоглогч бус. Бидний хийх ёстой, өөрөөс хамаарах асуудал бол өөрчлөлтөд дасан зохицож оршин тогтнох, хөгжих чадвараа л бэхжүүлэх. Үндэстний дархлаагаа бэхжүүлэх. Үүнийг чадварлаг төргүйгээр хийх боломжгүй.

Улам бүр сулран доройтож байгаа төрийн тогтолцооны задралыг зогсоож, улс төрийн тогтолцоогоо эрүүлжүүлэх, төрийн албыг бэхжүүлэх, улмаар аюулгүй байдлаа хамгаалах, хөгжлийн асуудлыг шийдвэрлэхүйц төрийг нэн даруй төвхнүүлэхээс илүү тулгамдсан асуудал Монголд байхгүй.

Төрөө төвхнүүлэх нь нэг талаас улс үндэстний оршин тогтнолын баталгаа, нөгөө талаас хөгжилд хүрэх, ард иргэдийн сайн сайхан амьдралыг буй болгох арга зам. Тиймээс засаглалаа сайжруулах асуудлыг хойш тавиад ярьж байгаа ямар ч эдийн засгийн уриа лозун амжилт олохгүй.

Монгол Улс өнөөдөр Гитлер төрөх нөхцлийг бүрдүүлсэн Вайменийн Герман, 12 жилд 21 Засгийн газар сольсон Францын дөрөвдүгээр бүгд найрамдах улстай адилхан тогтолцоотой байгаа. Парламентдаа Засгийн газар байгуулах, төсөв мөнгө хуваарилах хязгааргүй эрх мэдэл олгосноороо тэр үеийн Герман, Франц улсууд улс төрчдөд эрх мэдэл, эд баялгийн төлөө тэмцэлдэх үүд хаалгыг нээж, улс орны амьдралын гол ачааг үүрэх ёстой Засгийн газар, төрийн албаа хүчгүйдүүлж, улс орондоо эх захгүй улс төржилт, эмх замбараагүй байдал үүсгэх, иргэд хатуу гар, хүчтэй лидер хүсэх, улмаар дарангуйлагч төрөх замыг ч нээсэн байдаг. Парламент хэмээх олон хүн хамтын шийдвэр гаргадаг, хянахад төвөгтэй институцэд гол эрх мэдлийг өгснөөр хариуцлага хүлээх эзэн байхгүй болдгийг түүх харуулж байна. Герман, Франц улсууд Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулж, Засгийн газраа байгуулах, төсөв санхүүгээ удирдах эрх мэдлийг Ерөнхий сайд, гүйцэтгэх засаглалын тэргүүндээ өгснөөр улс төрийн алдаагаа залруулж чадсан.

Монгол Улс шинэ дугуй бүтээх эрэлд гаралгүйгээр бусад парламентын улсуудын жишгээр Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулах цаг болжээ. Ингэхгүйгээр өнөөгийн хямралыг

туулах, тулгаран ирж байгаа цаг үеийн сорилтыг тэсч, давж гарах тухай ярих боломжгүй болж байна.

Үүнтэй зэрэгцэн төрийн албаны цогц шинэчлэлийг эхлүүлэх цаг болжээ.

Монголын төр хийх ёстой, ёсгүй ажлуудыг тодорхойлж зааглах, үндсэн ачаагаа үүрэх чадавхийг нь бэхжүүлэх, төр авилгад автах гол шалтгаан болж байгаа төрийн аж ахуйн үйл ажиллагаанд оролцох оролцоог хязгаарлах, төрийн алба мэргэшэх, чадваржих, тогтвортой ажиллах нөхцлийг хуулиар маш тодорхой зохицуулж, амьдралд хэрэгжүүлэх шаардлага үнэхээр тулгамдаж байна.

Энэ хоёр том өөрчлөлтийг хийхгүйгээр өнөөдрийн халуун сэдэв болж байгаа улс төрийн намын шинэчлэл улс оронд бодитой дэвшил авч ирэх боломжгүй. Монгол Улс нам бус, төр төвтэй үндэстэн болох Үндсэн хуулиа батлаад 25 жилийн нүүр үзэх гэж байна!

Монгол Улс, монгол үндэстний оршин тогтнолын баталгаа болсон төрөө төвхнүүлэх ажлыг өнөөдөр л ханцуй шамлан эхлэхгүй бол оройтох, улс орон, ард иргэд маань багагүй золиос, төлөөс төлөх эрсдэл өндөр байна. Энэ бол нэг хоёр улс төрийн нам, цөөн улс төрчдийн тооцоо судалгаагүй, сэтгэлийн хөдлөлөөр хийх ажил биш. Улс төрийн хүсэл зориг, иргэний идэвхээр, олноороо сэтгэл шулуудан зүтгэх ёстой ажил. Үүнд улс төрчдийн төдийгүй эрдэмтэн судлаачид, сэхээтнүүдийн манлайлал ихээхэн чухал үүрэгтэй билээ.

Монголчууд бид 1990 оны цагаан морин жил нийгмийн шинэ өөрчлөлтийн төлөө эрчтэй давалгаа үүсгэж чадсан шигээ дэлхийг хамарсан их өөрчлөлтийн энэ цаг үед нийтээрээ сэргэж, төр улсаа өөд татахад хүчин зүтгэх цаг нэгэнт иржээ. Монголын төр оршиж байж, монгол хүний оршихуй, эрх, эрх чөлөө баталгаажна. “Төр төмбөгөр, ёс ёмбогор” гэж ардын үг бий. Төрт ёсны баялаг уламжлалаа сэргээн судалж, олон улсын хөгжлийн чиг хандлагыг зөв мэдэрч, тусган улс нийгмээрээ сэргэн хөгжих урам, эрч хүчийг бид зөвхөн дотроосоо л буй болгож чадна. Монгол Улс өнөөдрийнхөөс хавьгүй хүнд нөхцөлд тусгаар тогтнолоо сэргээн бататгаж чадсан, хурдтай дэгжин хөгжсөн үндэстэн билээ.

МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн дэргэд шинэ тутам байгуулагдаж буй Бодлогын судалгааны төв өнгөрсөн 9 дүгээр сараас эхлэн судалгааны хоёр төсөл хэрэгжүүлж байна. Нэг нь “Гадаад бодлогын шийдвэр гаргах механизмыг боловсронгуй болгох нь” сэдэвтэй бөгөөд Элчин сайд, доктор Ж.Энхсайхан уг судалгааны багийг удирдан ажиллаж байна. Хоёр дахь нь “Турван улсын эдийн засгийн коридорыг Монгол улсын гео-эдийн засгийн сонирхолтой уялдуулах нь” сэдэвтэй, доктор Ж.Гөлгөө тэргүүлэн ажиллаж буй. Энэ хоёр сэдэв хожуулаа манай улсын хувьд чухал ач холбогдолтой, нэн тулгамдсан асуудлууд гэдэг нь ойлгомжтой билээ.

Эдгээр бодлогын судалгааны ажлууд 12 дугаар сарын дундуур дуусч холбогдох байгууллага, хүмүүсийн гар дээр очих учиртай. Гэвч манай “тогтмол хэвлэлийн” анхны дугаар гарч буйг ашиглан уншигч олондоо учиг утгаас нь товчхон ч атугай танилцуулах нь зүйтэй болов уу хэмээн судлаачиддаа хандсан юм. Болгоох ажаамуу.

Бодлогын судалгааны төвийн дарга Х.Бэхбат

Б.Индра

МУИС-ийн ОУХНУС-ийн Бодлогын судалгааны төвөөс хэрэгжүүлж буй

“Турван улсын эдийн засгийн коридорыг Монгол Улсын гео-эдийн засгийн сонирхолтой уялдуулах нь” төслийн багийн гишүүн

Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын байгуулахаар тохиролцсон Эдийн засгийн коридорын асуудал юуны өмнө Монгол Улсад амин чухал агаад түүний эерэг, сөрөг талыг төрийн байгууллагуудын зэрэгцээ хараат бус шинжээчид судлаж дүгнэх нь чухал ач холбогдолтой. Иймээс Бодлогын судалгааны төв энэ сэдвийг сонгон төсөл хэрэгжүүлж буй бөгөөд эл судалгааны үр дүнд эдийн засгийн коридорын талаар монголын байгууллагуудаас баримталж ажиллах бодлого, арга тактикийн талаар зөвлөмж гаргах зорилт тавьсан юм. Эхний ээлжинд судалгааны агуулгаас товчлон хүргэж буй бөгөөд цувралаар дэлгэрэнгүй танилцуулах болно.

“Талын зам”: Монгол Улс дэд бүтцээ хөрш орнуудтайгаа уялдуулан хөгжүүлэх албан ёсны санаачилгаа 2014 онд “Талын зам” нэршлээр дэвшүүлжээ. Энэ санаачилга нь өндөр хурдны авто зам, төмөр замын техникийн шинэчлэл, газрын тос дамжуулах хоолой, өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, өндөр хурдтай интернэтийн шугам зэрэг дэд бүтцийг хамарсан юм.

“Нэг бүс, нэг зам”: Хятад улс 2013 онд “Нэг бүс, нэг зам” санаачилга дэвшүүлж, бүс, тив дамнан 60 гаруй улс орныг хамарсан хамтын ажиллагааг эхлүүлэхээ зарласан. Баримт бичгийн түвшинд 2015 оны 3 дугаар сарын 28-ны өдөр “Торгоны замын эдийн засгийн бүс ба ХХI зууны далайн торгоны замыг хөгжүүлэх алсын хараа ба үйл ажиллагаа” батлагджээ. Уг баримт бичигт Хятад улс хуурай газраарх олон улсын томоохон гарцдаа тулгуурлаж, зам дагуух том хотууддаа түшиглэн,

Гурван улсын эдийн засгийн коридорыг Монгол Улсын гео-эдийн засгийн сонирхолтой уялдуулах нь

худалдаа, эдийн засаг, үйлдвэрлэлийн бүсийг хамтын ажиллагааны талбар болгон, Ази, Европыг холбосон “гүүрийг” хамтран байгуулах тухай заажээ. Үүний тулд эх газрын чиглэлд зургаан том эдийн засгийн коридор байгуулахаар тусгасны нэг нь Монгол, Орос, Хятад гурван улсын коридор билээ.

“Евразийн эдийн засгийн холбоо”: ОХУ 2014 онд Беларусь, Казахстан улсын хамт “Евразийн эдийн засгийн холбоо” байгуулснаа зарласан. Энэ холбооны гишүүн улсууд интеграцчлалын илүү өндөр түвшинд шилжих ба дээрх гурван улс хооронд бараа таваар, ажил үйлчилгээ, эд хөрөнгө, ажлын хүчийг чөлөөтэй шилжүүлэх, мөн эдийн засгийн голлох салбар болох эрчим хүч, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, зам тээврийн бодлогоо харилцан зөвшилцөх ажээ.

Гурван талын тохиролцоо:

Монгол Улс, ОХУ, БНХАУ шил дараалан дэвшүүлсэн дээрх гурван стратеги, бодлогуудаа уялдуулах үүднээс 2015 оны 7 дугаар сарын 9-нд Уфа хотноо болсон төрийн тэргүүн нарын уулзалтаар гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэх

“Замын зураглал” боловсруулахаар болж, улмаар “Монгол-Орос-Хятадын хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг боловсруулах тухай Санамж бичгийг байгуулсан байдаг.

Үүнээс жилийн дараа 2016 оны 6 дугаар сарын 23-24-ний өдөр гурван улсын төрийн тэргүүн нар Ташкент хотноо уулзах үеэрээ “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрт гарын үсэг зурсан нь хөрш гурван орны харилцаанд шинэ үеийг нээв.

“Монгол-Орос-Хятадын хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-т 32 төслийг хэрэгжүүлэхээр тохиролцсон. Энэхүү коридорыг байгуулах зорилгын хүрээнд хоорондоо уялдаатай хэд хэдэн шат дараалсан зорилтууд тусгагджээ:

Нэгд, коридорыг үүсгэн байгуулж хөгжүүлэх чиглэлүүд нь хагуу болон зөөлөн дэд бүтцийн аль алийг нь хамарч буй. Тодруулбал, дэд бүтэц, хил дамнасан тээврийг дэмжих төдий биш, түүнд хамаарах хууль-эрх зүй, стандарт-мэдээлэл зүй, мэргэжлийн боловсон хүчин зэргийг хамтад нь хөгжүүлэхэд чиглэсэн төслүүдийг мөн хэрэгжүүлэх замаар гурван талт хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Хоёрт, тал тус бүрийн давуу талыг ашиглах, өрсөлдөх чадварыг нь бэхжүүлэх үндсэн дээр харилцан ашигтай эдийн засгийн хөгжлийн орон зайг коридорын дагуу бүрдүүлнэ.

Эцэст нь, гурван улсын эдийн засгийн хөгжлийн стратегийг уялдуулж, улмаар эдийн засгийн интеграцлалыг бүрдүүлэн гүнзгийрүүлэх хэтийн зорилтыг агуулж байна.